

“ДЦС-4” ТӨХК

Огноо: **2019 оны 05 дүгээр сар 08**

**ЖИМС, ЖИМСГЭНЭ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалт/ гэрээний
дугаар:

ХХА-2019/237

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

ДЦС-IV ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Жимс жимсгэнэ нийлүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2019 оны 05-р сарын 15-ны өдрийн 10.000 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 05-р сарын 15-ны өдрийн 10.30-т** цахим системээр нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 311,312 тоот өрөө
Утас:70181309, 7017-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) ТООЗ-д заасан шаардлагууд
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. **Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.**
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь нэг багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ



ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн нэг жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: 2019 оны 05-р сарын 15-ны өдөр Цаг: 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот.Баянгол дүүрэг. 20-р хороо. “ДЦС-4” ТӨХК. Давхар болон өрөөний дугаар: 310 тоот Огноо: 2019 оны 05 дүгээр сарын 15 -ны өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ХХА-2019/237 Жимс, жимсгэнэ нийлүүлэх нэг багцаас бүрдэнэ</p>

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Нэг жилд нийлүүлэх боломжит тоо хэмжээ	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			Тайлбар
				Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа	
Польш алим	600	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Мандарин	150	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Усан үзэм	150	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Лийр	150	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Апельсин кг	180	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Гадил	150	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Үзэм	1500	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Хар чавга	300	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Чангаанз	200	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Бурам	250	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Лимон	500	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Киви жимс	100	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ
Улаан чавга	50	кг	"ДЦС-4" ТӨХ-н ЭЗГ агуулах	Гэрээ байгуулсан өдрөөс	Гэрээ байгуулсан өдрөөс Нэг жил		Хавсралтаар нэгж үнийн санал ирүүлнэ

Төрөл бүрийн жимс жимсгэнэд тавигдах техникийн ерөнхий шаардлага

д/д	Нэр	Гарал үүсэл	Хэрэглэх зориулалт	Төлөв байдал	Амт, өнгө	Тоо хэмжээ	Сав баглаа боодол	Нөөшлөх жин	Зураг
1	Алим	Польш, америк, орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Шүүслэг, улаан	550кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
					Шүүслэг, ногоон	50кг			
2	Мандарин	Орос	Салат зууш, соус хийх, buffet	Жимсээрээ	Исгэлэн өвөрмөц, улбар шар	150кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
3	Усан үзэм	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Бор хүрэн	50кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
					Хар	50кг			
					Ногоон	50кг			
4	Лийр	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Улаан ногоон шар шүүслэг	150кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
5	Апельсин	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Улбар шар шинэ исгэлэн	150	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
6	Гадил	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Ногоон, шар шинэ зөөлөн	180кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
7	Үзэм	Хятад, орос	Жимсний шүүс, салат хийх	Жимсээрээ	Бор, шар шинэ зөөлөн	1500	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
8	Хар чавга	Польш хятад орос	Салат зууш, соус хийх, ххол амтлах	Хатаасан	Хар шинэ ястай, ясгүй зөөлөн	300кг	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	
9	Чангаанз	Польш хятад орос	Салат зууш, соус хийх, хооломтлах	Хатаасан	Улбар шар шинэ	200	Хайрцаг баталгаажуулалт	Кг-р	

10	Бурам	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Савлагаатай	Бурам	250	Уут баталгаажуулалт	1кг	
11	Лимон	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Шаргал исгэлэн	500	Уут баталгаажуулалт	Кг-р	
12	Киви жимс	Польш хятад орос	Салат зууш, соус хийх	Жимсээрээ	Ногоон исгэлэн	100	Хайрцаг, баталгаажуулалт	Кг-р	
13	Улаан чавга	Польш хятад орос	Шеленд	Жимсээрээ	Цагаан шаргал	50	Хайрцаг, баталгаажуулалт	Кг-р	

1. Ерөнхий шаардлага: Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төв шинжлүүлсэн шинжилгээний бичигтэй, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх.
2. Барааны шаардлага: Хүнсний бараа тус бүр дээр танилцуулга, зураг хавсаргана. Жич: Барааны нэр төрөл бүрт амталгааны дээж болгон бүтээгдэхүүн бүрээс 200гр-аар авчирах. /Дээж буцаахгүй нөхцөлтэй болно/.
3. Чанарыг үнэлэх: Тухайн дээж ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүнээр хоолны орц нормын дагуу хоол хийж амталгаа, бие бүтэц, гарц байдлыг нь тодорхойлж шаардлагад нийцэх эсэхийг магадлана.
4. Баглаа, боодол: Стандартын дагуу савласан баглаа боодолтой, хайрцаг савны хийц, битүүмжлэл сайтай, бүтээгдэхүүний шошго найрлага бичигдсэн байх.
5. Бараа хүргэх газар: “ДЦС-4” ТӨХК-ийн хүнсний агуулахад нийлүүлэгч өөрийн хүнсний зориулалтын машинаар хүргэнэ.
6. БАРААН ДЭЭР НЭГЖ ҮНИЙН САНАЛ ИРҮҮЛНЭ.
7. Нийлүүлэх хуваарь: ДЭЭРХ БАРААГ НЭГ УДААГИЙН ХУДАЛДАН АВАЛТААР АВАХГҮЙ ГЭДГИЙГ АНХААРНА УУ. Гэрээ байгуулснаас хойш 7 хоногт 1-2 удаа захиалга хийгдэх бөгөөд захиалсан тоо, хэмжээгээр нийлүүлэх чадвартай байна. Гэрээ нэг жилийн хугацаанд үргэлжилнэ.

Дөрөв. Жимс, жимсгэнэ нийлүүлэх үнийн саналын маягт

[огноо]

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нэгж үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу захиалгаар нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа [нэг] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. Зах зээлийн үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд өрсөлдөгч компаниудын үнийн харьцуулалтыг үндэс болгоно |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Захиалагч чанарын баталгааны бичиг, худалдан борлуулах зөвшөөрлийг шалгана.
1.2. Нийлүүлэх барааны сав, баглаа боодол нь баталгаажсан эсэхийг шалгана |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь, зарлагын баримт;
2) барааны гарал үүслийн гэрчилгээ.
1 жилийн хугацаанд саадгүй нийлүүлнэ. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн болон ашиглалтын явцад баглаа боодол гэмтсэн, чанар өнгө үзэмж алдагдсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Нийлүүлэгчид Урьдчилгаатөлбөр олгохгүй бөгөөд гэрээгээр нийлүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэх зарлагын баримт, холбогдох баримтуудыг үндэслэн захиалагч бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг хийнэ. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны үнийн дүнд хэтэрсэн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.
Захиалагч нийлүүлэгчийн төлбөрийг хугацаа хоцроосон тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн хэтэрсэн хоног дутамд 0,1%-ийн алданги ноогдуулна.
Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 30%-аас хэтрэхгүйбайна. |

БАТЛАВ.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИРАЛ

ЗАХИРАЛ

ЖИМС, ЖИМСГЭНЭ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас **“ДЦС-4” ТӨХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **ХХК** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **Жимс, жимсгэнэ нийлүүлэх ХХА-2019/237** г (цаашид “бараа” гэх) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч 1 жилийн хугацаатай гэрээг байгуулав.. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг захиалагчийн захиалгын дагуу нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Үнийн санал;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ДЦС-4” ТӨХК-ИЙН

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: